



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/194

Мандалговь

Зорилтот бүлгийн болон нярай  
хүүхдүүдэд бэлэг гардуулах тухай

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.1, 16.4.2, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.1, Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 31 -ний өдрийн 318 тоот тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын.2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 8 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан аймгийн төрөх тасагт төрсөн нярай болон хөгжлийн бэрхшээлтэй, бүтэн өнчин 109 хүүхдэд бэлэг гардуулсугай.

2. Бэлэг гардуулах хүүхдийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар, хүүхдийн бэлгийн зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хүүхдийн бэлэгт зарцуулагдах нийт 3,562,070 (Гурван сая таван зуун жаран хоёр мянга далан) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210535